

МОНГОЛ, ТҮРЭГ ХЭЛТНИЙ ДОМОГ, ЯРИА ДАХЬ
ЧОНЫН ДҮРИЙН ХАРЬЦУУЛАЛ

Ү.Хастана
Б.Хишигсүх

Агуулгын товч: Монгол, түрэг хэлтний домог, домог ярианд өөрийн угсаа гарлаа чонотой холбож үздэг зүйлс маш олон харагддаг. Хэдийгээр угсаа гарлын домгийн үйл явдлын мотив нь адилгүй боловч домгийн цөм болох чоно шүтээний байр суурь нь хувирсангүй мөртөө эдгээр үндэстний соёл, зориг санааны бэлгэдэл болж бүхий л умард оронд уламжлагдан дэлгэрчээ. Монгол домог, домог яриа дахь чонын дүрийг түрэг хэлтнүүдийн угсаатны домогт илэрдэг чонын дүртэй харьцуулж үзвэл нэлээд олон адилавар талтай байдаг. Тэдгээрийн гол мотив хийгээд үндсэн ойлголт нь их төлөв адилхан буюу ойролцоо байж бүр бөө мөргөлийн дээд шүтээн болох хөх тэнгэрт холбогдох дээр төвлөрч байна.

Түлхүүр үг: *Монгол, түрэг хэлтэн, домог, домог яриа, чонын тухай*

Домог бол урлагийн нэгэн зүйл болсны хувьд хүмүүсийн балар эртний үеийн сэтгэхүй, тухайн үеийн амьдралын байдлыг зохих хэмжээгээр харуулж чаддаг. Чоно нь ямагт монгол, түрэг хэлтний угсаа гарлын домогт илэрдэг юм. Угсаа гарлын домог бол нийт домог доторх хамаг эртний нэг хэлбэр болох бөгөөд нэлээд нь бүр тотем шүтлэг лүгээ нягт холбоотой байдаг. Тэгэхлээр бас “Тотемын домог” ч гэдэг. Иймэрхүү угсаа гарлын домог монголчуудын дунд байхаар барахгүй дэлхийн олон улс үндэстэнд түгээмэл харагдана. Балар эртний хүмүүс өөрийгөө байгалиас ялган салгаж үздэггүй байсан ба өөрсдийгөө сав шим байгалийн нэгэн хэсэг юм гэж эсвэл бүр ч тухайн овог аймгийнхаа аль нэг дүрсийн ургамал амьтантай, хааяа заримдаа амьгүй зүйлтэй ч гарал төрөл нэгтэй юм гэж итгэж байжээ. Тэр дундаас хэсэг бүлэг хүн, нэг овгийн өөрсдийгөө голдуу аль нэг амьтантай далд нууцлаг холбоотой юм гэж үзээд тэр амьтаныг алж намнах, идэх эдлэхийг хориглодог байсан байна. Ингэхлээр угсаа гарлын домог нь чухамдаа овог төрлийн байгууллын үеийн бүтээл гэж үздэг бөгөөд зан үйл, шүтлэг, домог зүйн үүслийн нэгэн шат байжээ.

Монгол, түрэг угсаатан бүр адил язгуур хэлтэнд харьяагдах тул үг хэлний талаар адил буюу ойролцоо газар маш олон буй. Харин угсаа гарлын хувьд эдгээр үндэстний хооронд чухам ямар харьцаа холбоотой болохыг түүхчдийн байр суурь адил бус. Гэхдээ эдгээр үндэстнүүд эрт язгуураас урьд хожид адил нутаг орон юмуу хөрш зэргэлдээ оршин амьдарч мандаж буурсан түүхтэй болохоор үндэстний бүрэлдэл, соёлын тогтолцооны талаар ямар нэгэн харьцаа холбоо буюу адил ойролцоо газар байх нь олон талаар ажиглагдаад байдаг. Угсаа гарлын домог, домог яриа ба чоныг шүтэх зан үйлийн хувьд адил тал олон байдаг нь үүний нэг нийтлэг жишээ болох юм. Монгол, түрэг хэлтнүүдийн үлгэр домогт өөрийн угсаа

гарлаа чонотой холбож үздэг зүйлс маш олон харагддаг. Тэдгээрийн гол мотив хийгээд үндсэн ойлголт нь их төлөв адилхан буюу ойролцоо байж, бүр бөө мөргөлийн дээд шүтээн болох хөх тэнгэрт холбогдох дээр төвлөрч байна.

Нэг. Хүн ардыг аварч тэтгэдэг чонын дүр

“Монголын нууц товчоо” хуудас эхэлмэгц “Чингис хааны язгуур дээд тэнгэрээс заяат төрсөн Бөртэ чоно ажгуу. Гэргий нь Гоа марал ажээ. Тэнгис гэтэлж ирэв. Онон мөрний тэргүүн Бурхан халдунаа нутаглаж төрсөн Батцагаан ажгуу” (МНТ, 1980:1) хэмээн Бөртэ чоно, Гоа марал хоёрыг монголчуудын өвөг дээдсийн хувиар тэмдэглэж буй. Энэ нь түүх бичигт тэмдэглэгдсэн чоно бол Гоочэ, турк мэтийн умартын аймаг үндэстний өвөг дээдс мөн болсны хувьд аюул түгшүүртэй үед үр язгуураа аварч тэтгэдэг дүрээр илэрдэг.

“Судар, тэмдэглэл”, “Жоу улсын бичиг”, “Умард төрийн түүх” зэрэг сурвалж бичгүүдэд хээр хаягдсан нялх хүүг хөх чоно ирж сүүгээрээ тэжээж амь оруулсан тухай тэмдэглэж байхад, Лувсанчойдоны “Монгол зан аалийн ойлбор”-т харин түүн лугаа адилавар “Шаалуу хүүгийн үлгэр” орсон буй.

Эрт цаг Хэрлэн голын хөвөө газар авлах үед нэг өлөгчин чоно дөрвөөд настай хөвгүүнийг дагуулан явахыг үзээд авны хүн чоныг хөөж явуулаад бяцхан хүүг олж аваад тэжээж Шаалуу гэж нэрлэжээ. Энэ хүү чонын хэлийг мэддэг. Хожим Чингис хааны цэрэгт орж хээр шөнө цаг ан улих үед Шаалуугаас юу гэж баймуу хэмээн асуун мэдэж явдаг гэнэ (Лувсанчойдон, 1981:247).

Үлгэрт чоно нь хүүхдийг тэжээн өсгөсөн мотив гардаг мөртөөн Шаалуу хүүгээр дамжин хүнийг аюулаас авардаг дүрээр илэрч байгаа юм. Киргиз ардын дунд бас иймэрхүү үлгэр уламжлагдаж буй:

Эрт урьд цагт багаасаа өвчтэй нэг зэрэмдэг хүүг эцэг эх нь хээр аваачиж орхижээ. Тэгэхэд нэг өлөгчин чоно тэр хүүг хөхүүлэн тэжээж хүдэр эр болгов. Хожим нь тэр хүүг хүмүүс олж аваад гэртээ авчирч “Хав” гэх нэр өгчээ. Түүний үс нь чонын талтай адилавар тул хүмүүс түүнийг “Урт үст хав” гэж дууддаг гэнэ. Тэр хүүгээс үр хүүхэд үржээд нэгэн аймаг болсон нь Хав аймаг гэж нэрлэсэн гэнэ (满都胡主编, 1997:91).

Монголын Шаалуу хүүгийн үлгэр нь түрэгийн ашина овгийн домог жич киргизийн үлгэрийг бодбол чоно хэрхэн хүүг тэжээж өсгөсөн тухай нарийн тэмдэглэсэнгүй боловч бид энэ хэдэн домог, үлгэрийн харьцууллаар дамжин монгол үлгэрийн өөр дүрс нь мөн киргизийн үлгэртэй адил үйл явдлын мотив байсан гэж бүрэн таамаглаж болно. Монголын зарим орны бүүвэйн дуунд “Шаалуу бүүвэй” гэх үг гардаг (Лувсанчойдон, 1981:247). “Шаалуу” гэдэг нь чонын нэрийдэл болох учир, энэ нь хэрэг дээрээ чонын бүүвэй гэх утгатай үг болно.

“Шинэ Тан улсын бичиг”-ийн 217 дугаар ботид “Хүн биетэй, чоно толгойтой” эзэд сахиулсан ирж Шиүвэй Ян Түвээ аймгийг мөхлийн аюулаас аврав хэмээн тэмдэглэж буй (满都胡主编, 1997:12). Ийм аман уламжлал одоо ч гэмээн турк хэлт үндэстэн (жишээлбэл Уйгур, Хасаг, Киргиз)-ийн дунд уламжлагдаж байх бөгөөд аюул түгшүүртэй үед чоно хүнийг авардаг гэх үндсэн мотивын хувьд адилхан байна. Уйгурчуудын нэг домог ярианд:

Нэг удаа уйгурчууд дайсанд ялагдаж, уулын бэлд бүслэгдээд сөнөж мөхөхөд хүрчээ. Энэ үес нэг чоно ирж тэднийг дагуулан уул агуйгаар орж агуйн чанадах өвч бэлчээр сайтай тал газар авчирчээ. Ингээд уйгурчууд нэг удааны мөхлийн аюулаас хэлтэрсэн гэнэ. Тэр цагаас эхлэн уйгурчууд чоныг ид шидтэй амьтан гэж шүтдэг болж гэнэ (满都胡主编, 1997:41).

Үүнтэй адилаар “Нууц товчоо”-ны 26 дугаар зүйлд Бодончарыг ах нартаа мунхаг бядуу гэж гологдон хувь эс олгоод гарч ирсний сүүлээр “Идэхүй идээ үгүй ард, чонын гоод хургасан хөрсөн мирж харваж алж идэлдээд чонын идсэнийг тэмхэлдэж идээд... тэр

он гарав” (МНТ, 1980:38) хэмээн тэмдэглэж байдаг. Энэ тэмдэглэлд хүн нь чонын хишигт шүтэгдэн их байгалийн баялаг санг хамтаар эдэлж байсныг харуулж байгаа юм. Иймэрхүү заншил зарим газар мөн үлдэгдсээр буй. Жишээлбэл, “Өнөөгийн Шинжааны Баянголын торгуудууд, Хөхнуурын хошуудад чонын идэж үлдээсэн сэг, чонын барьсан мал адгуусын махыг идвэл сайн гэх сүжиг бишрэл өнөө хүртэл байсаар гэнэ (Хүрэлшаа, 1996:4). Киргизчүүд одоо хүртэл чононд холбогдох зан үйл олон буй. Тэднүүс чоныг шидэт эдээр үзэж чонын махыг төрөх гэж байгаа бүсгүйд тустай гэж ойлгодог бөгөөд чонын шагыг сахиа болгон хүүхэддээ зүүлгэдэг заншилтай.

Хоёр. Хөх тэнгэртэй холбогдох шидэт амьтан

“Вэй улсын бичиг”-ийн зуун гуравдугаар боть “Гоочэгийн цадиг”-т тэмдэглэсэн нь:

Хүннүгийн Чэн Иү хаан хоёр охинтой бүлгээ. Өнгө зүс маш гуа болохоор хүмүүс бүр тэр хоёрыг тэнгэрийн дагина гэгцгээдэг. Чэн Иү хаан: Энэ хоёр охиноо тэнгэр нартай ураглуулсугай хэмээн нутгийнхаа хойт талд хүнгүй газар өндөр тагт босгож дээр нь хоёр охиноо тавиад: “Тэнгэр ирж буулган авна уу?” хэмээн даатгаад явав. Гурван жилийн дараа эх нь явж охидоо авч ирэх хэмээсэнд Чэн Иү зөвшөөрсөнгүй. Дахин нэг жилийн дараа нэг хөгшин чоно ирж сонжин тагтыг сахин улих болжээ. Тагтын доор хөндий нүхтэй өнөө чоно ер явж одохгүй. Үүнд бага охин нь: “Манай эцэг бидэн хоёрыг тэнгэртэй ураглуулах гэж энд тавьсан биш үү, энэ чоно тэнгэрээс буулгасан шидэт амьтан мөн магад” гэж хэлээд тагтаас бууж хөгшин чонотой нөхцөж улмаар өсөж үржин нэг аймаг улс болсон гэнэ. Тэдний үр хойчис нь чоно улих шиг уртын дуу эгшиглүүлээд дуулдаг гэнэ (魏收, 1974:2307). Вэй улсын бичиг”-т тэмдэглэгдсэн домогт Гоочэгийн өвөг дээдэс, онгон шүтээн болох өнөө хөх чоныг Чэн Иүгийн бага охин “Тэнгэрийн зоригоор ирсэн сахиулсан магад” гэж үзжээ. Тухайлбал чонын тус бие нь хэдийгээр тэнгэр биш боловч түүний илэрсэн нь тэнгэрийн захирлаар болсон, тэр бол тэнгэрийн зориг санааны илэрхүүн болох ид шидэт амьтан мөн. “Умарт төрийн түүх”-т бас түрэгчүүдийн өвөг дээдэс, онгон шүтээн болох энэ чоныг дайсны цэрэг алахаар ирсэнд “Гэнэт тэнгэрээс нэгэн ид шидтэй амьтан бууж ирээд” авран гаргав гэж тэмдэглэгдэж буй. “Огуз хааны домог яриа”-нд бас “Тэнгэрийн гэрлээс илрэн бүхий хөх чоно” (耿世民译, 1980:20) хэмээн тэмдэглэж буй. Энэ нь “Алунгоа эхийн домог яриа”-тай адилаар чонын шидэт чанарыг илэрхийлэхдээ тэнгэрийн шүтлэг ба нар сарны гэрлийн шүтлэгийг уялдуулан нэгтгэсэн юм. Монголчууд аль эртнээс чоныг тэнгэртэй холбон үзэж, шидэт амьтнаар үздэг. “Нууц товчоо”-нд дээр тэнгэрээс заяат төрсөн Бөртө чоно” гэж тэмдэглэгдэж байгаагаас гадна “Алунгоа эхийн домог яриа”-д энэхүү холболдолго нэн тодорхой харагдана.

“Монголын нууц товчоо”-ны 17-22 зүйлд Алунгоа эхийн домгийг тэмдэглэсэн байдаг. Алунгоа эх Добу мэргэн нөхрөө нас барсны хойно Буха хатиги, Богд Салжай, Бодончар мунхаг нартай гурван хөвгүүн төрүүлжээ. Хоёр ах нь дүүгээ эд лав гэрийн зарц Малиг Баягудай овгийн хүний хүүхэд буй а хэмээн үг хэлэлцэхэд Алунгоа эхийн сэтгэл зовниж, хаврын нэгэн өдөр тэднүүсийг сургамжлан Бэлгүнүтэй, Бүгүнүтэйд ийн өгүүлжээ.

“...Шөнө бүр цэгээн шар хүн гэрийн өрхийн тотгоо хээгээр орж хээли минь бэлж, гэгээ нь хээлид минь шингэх бүлгээ. Гарах наран сарны хилээр шар нохой мэт шарвалзаж гарах бүлгээ. Дэлэм ихэн өгүүлээд та түүгээр ухваас тэмдэг нь тэнгэрийн хөвгүүд буй яа. Хар тэргүүт хүнд ханилан ихэн өгүүлээд та. Хамгийн хаад болбоос харцас тэнд одхонуу” хэмээв (Элдэндэй, Ардажав, 1986:35).

Тус домог яриа бол түүхэн үнэн хийгээд шидэт үлгэрийн уламжлалаар бүртгэгдсэн Монголын уг удам, угсаа гаралд холбогдсон домог яриа юм. Үүнд “Цэгээн шар хүн” “гэгээн”, “шар нохой” гэх гурван уур дүрс гол цогц болон илэрч буй. Үүнд “шар хүн”, “шар нохой”-н “шар өнгө” болон “гэгээн” нь монгол, түрэг угсаатны эртний нар сарны шүтлэг,

тэнгэрийн шүтлэгтэй холбоотой юм. “Монголын нууц товчоо”-оос гадна Чингис хаан, Төмөр нарын тухай эртний түрэг туужид Алунгоа эхийн эр нөхөр нь таалал болохын өмнө “бие барснаас хойш нарны гэрэл болон сацран ирээд чонын дүрээр буцаж явна” гэж гэрээсэлдэг бөгөөд Алунгоа бусдыг үл үнэмших болуузай хэмээн гэрийнхээ үүдэнд харуул гаргахад тэнгэрээс гэрэл болон бууж ирээд, дараа нь чоно болон гарсан тухай өгүүлдэг байна (Дулам, 1999:50). Энэ нь тэнгэрийг бишрэх үзэл ба бөө мөргөлийн оройн шүтээн нь тэнгэр болохтой холбоотой ойлголт гэдгийг судлаачид санал нэгтэй үзэж байна.

Монголчууд мөнх тэнгэрийг шүтэх учир, тэнгэрийн шидэт амьтан болох чоныг шууд дуудахгүй харин “тэнгэрийн нохой”, “тэнгэрийн элч”, “цагаан аавын нохой”, “хөх нохой” гэх мэтээр хүндэтгэн нэрлэдэг нь чоныг тэнгэртэй холбосон утгаас салж чадахгүй тэр мөртөө тэнгэрээс заяагдах болсондоо л сая бөөгийн эзэд тэнгэр нарын хүлэг болдог.

“Даян Дээрхийн дуудлага”-д:

Зүүн зүгийн эзэн

Зүрхэн хар тэнгэр

Гал цог идэштэй

Галзуу чонын хүлэгтэй

Хүний махан хүнстэй

Хүрэл чулуун зүрхтэй

Бөгтөр чонын бөхтрөгтөөр ирдэг

Халтар чонын хадаргаар ирдэг

Хан гүжир тэнгэр минь (Дамдинсүрэн, 1979:447) гэж, төв халхын бөөгийн дуудлагад “Гал могойн ташууртай /галзуу чонын хүлэгтэй” (Гаадамба нар, 1984:576) гэж, ар хорчин бөөгийн дуудлагад “Сухай бүлжгээн ташуурт /сувай чонын хүлэгтэн” гэж гардаг билээ (Мөн тэнд, 587).

Чоныг шидэт амьтан гэж үздэг ухамсар нь бидний дээр дурдсан бичиг сударт тэмдэглэгдсэнээс гадна бидэнд олдогдож байгаа бусад аман уламжлалд ч харагдана. “Болдоггүй бор өвгөн” гэх домгийн агуулгыг товч дурьдвал:

Хурмастын хон хэрээ болдоггүй бор өвгөний хурмаст тэнэрийг тахина гэж байсан хургын нүдийг нь ухсан өвгөн уучилж, нисдэг бор морио унаж очоод хон хэрээний нүдийг нь ухсанд хурмаст тэнгэр “хон хэрээний минь нүдийг ухаж” гэж уурлаад хоёр чоноороо нисдэг бор морийг нь идүүлэхээр явуулж гэнэ (Мөн тэнд, 798). Үүнд чоно нь хурмаст тэнгэрийн захирал доор байгаа шидэт амьтанаар илэрдэг байна. Чоно хурмаст тэнгэрийн элчээр хүний ертөнцөд бууж ирээд буумалтай дайралдаж ялагдан дахин тэнгэрт буцсан домогт (Хүрэлшаа, 1996:29) чоно нь тэнгэрээс ирж, тэнгэртээ буцлаа гэдэг бол, дархадын уламжлалт хар сүлдийн тахилгын тухай домогт Чингис хаан нэг удаан дайнд ялагдах үед хан хурмаст тэнгэрээс хар сүлд саглагар модон дээр бууж ирж гэнэ. Тайлгын шүүс дутсанд үлдсэн дутуу тоог манай сүргээс хан хурмаст тэнгэрийн хөх нохой (чоно) чинь гүйцээд барьтугай гэж тахисан гэдэг (Сайнжаргал, Шаралдай, 1983:282). “Судрын чуулган”-д тэмдэглэснийг үндэслэвэл Өгэдэй хаан лалын шашинтны барьж авсан чоныг мянган лан мөнгөөр худалдан авч тавьж явуулснаар барахгүй тэр хүнийг нэг сүрэг хониор хүндэд шагнасан байна. Тавьж явуулсан тэр чоно дахиж авын нохойд баригдсанд Өгэдэй хаан ихэд гуниж өөрийн биед нь муу ирүү болов гэж сэжиг авчээ ([波斯]). Өгэдэй хааны чоныг тавин явуулж тэнгэрээс насан хутаг нэмж өгөхийг хүссэн нь мөн ч чоныг тэнгэртэй холбоотой шидэт амьтан гэж үздэг далдын ухамсартай холбоотой юм.

Чоныг тэнгэртэй холбож үздэг бас нэг тотем илрэл бол эл хэлний орчуулгад чоныг тэнд “Бөртэ чоно”, “саарал чоно”, “хөх чоно” гэж тэнгэрийн өнгө болох хөх өнгөтэйгээр тодотгодог байна. Энэ нь бөө мөргөлд тэнгэрийг оройн шүтээн болгодог болохоор хөх өнгийг хамгийн эрхэм өнгө гэж үздэгээс илрэлтэй. Бөртэ чоно гэдэг үгийг С.Ю.Неклюдов

“дэлхийн олон түмний домог үлгэрийн тольд саарал чоно (серый волк)” гэж орос хэлээр орчуулжээ. Профессор Ф.В.Кливез үүнийг англи хэлээр мөн үүнтэй ойролцоогоор орог хөх чоно (bluish Wolf) гэсэн утгаар орчуулжээ (Цэрэнсодном, 1988). Энэ хоёр орчуулга нь “Нууц товчоо”-ны хятад галиг, Мин улсын үеийн хадмал орчуулгыг үндсэндээ баримталсан байна. “Бөртэ чоно”-ыг олонх орчуулгад “Хөх чоно” гэдэг бөгөөд бас олон бичиг судар, домог тууль, бөөгийн дуудлагад “тэнгэрийн хөх нохой” гэх мэтээр монголчуудын дунд чоно дурсагдан дуудагдахдаа бүр л хөх өнгөөр илэрдэг.

Түрэгчүүд хөх гэдэг үгээр тэнгэрийг илтгэдэг. Хөх өнгө нь төрийн их өнгө болгож хөх өнгөөр тэнгэр, чоно, түрэгчүүдийг холбож, өөрсдийгөө хөх тэнгэрээс эстэй, хөх чоноос үүссэн хөх түрэгчүүд гэдэг. “Огуз хааны домог яриа”-д “хөх чонын жолоодлогоор хөвчин дэлхийг байлдан дагуулсан” хэмээн буй (耿世民译, 1980:19-25) монголчууд бөө мөргөлийг шүтэж байсан болохоор тэнгэрийг оройн шүтээнээ болгож “мөнх тэнгэрийн хүчин дор”, “тэнгэрийн хишиг”, “тэнгэр мэдэг”, “тэнгэрийн ивээл” гэж аливаа бүхнээ тэнгэрт даатгадаг байжээ. Тэрчлэн бүр өвөг дээдсээ дээр тэнгэрээс эштэй гэж тайлбарлаж тэнгэрийн өнгө болох хөх өнгийг хамгийн эрхэм өнгөөр үзэж түүнийг төрийн их өнгө болгож, өөрсдийгөө хөх монгол, хөх түрэг гэдэг байжээ.

Гурав. Дайсныг дарж дархан цолоо мандуулсан баатрын дүр

Угсаа гарлын домог, домог яриагийн олонхи нь тус үндэстний онго шүтээнтэй холбогдолтой. Гэхдээ шүтээн болох зүйл нь тус үндэстний угсааны гоо сайхны сонголт болохын зэрэгцээ олон нийтийн соёлын дүрдэс болох юм. Тийнхүү тэр нь баларлаг хүй нэгдлийн соёл сэтгэгчдийн билэгдэл болох тэрхүү үндэстний зориг санааны илрэл болдог байна. Тал нутгийн нүүдэлчин үндэстний чоно угсаа гарлын домог, домог яриа нь яриангүй эдгээр үндэстний эрэлхэг баатарлаг, эрэмгий чанга үндэстний зориг санааны илрэл болж үеийн үе өртөөгөөр уламжлагдан дэлгэрч ирсэн байна. Монголын баатарлаг тууль “Жангар”-т жангараас араг улаан Хонгорыг магтахдаа “түрэх дайсанд төмөр жадын үзүүр минь түшэн хонинд довтолдог төхгий улаан чоно минь” (Жангар, 1958:271) “олон хонинд довтолсон огтор хөх чоно мэт ашир улаан Хонгор” (мөн тэнд, 304) гэх мэтээр баатар эрийн эрэлхэг зоригийг чонын довтлолтоор зүйрлэн илтгэдэг байна.

Түрэгчүүд чоныг байлдааны сахиулснаар үздэг. Огуз хааны домог ярианд “хөх чонын жолоодлогоор хөвчин дэлхийг байлдан дагуулсан” гэж тэмдэглэгдэж буй (耿世民译, 1980:19-25). Түрэг хааны шадар хамгаалагчид өөрийгөө чоноор нэрлэдэг нь мөн ч чоныг эрэлхэг баатрыг дээдлэн үздэгээс болсон юм. Түрэг хэлний “Культегины хөшөө” (阙特勤碑) -д “бидний цэрэг чоно шиг, дайсны цэрэг хонь шиг” хэмээн чонын эрэлхэг дайралтаар баатар идтэнээ дүрсэлж байдаг (见突厥文, 1958:877). Уйгурчууд одоо болтол чоныг юунаас ч айхгүй эрэмгий зоригийн бэлтгэлээр үзэж, хүү төрвөл нэг чоно төрлөө гэж хэлдэг заншилтай. Хасаг үндэстний зүйр сэцэн үгэнд чоноор баатар эрийг дүрслүүлдэг. Бас зарим эдлэл дээр нь чонын бие дээр бүргэдийн толгой эсхүл бүргэдийн жигүүр ургуулж, арслан барс зүг давхин дүүлэн орж байх дүрсийг зурж байгаа нь эрэлхэг баатарлаг, эрэмгий зоригтой байгааг магтаал болгож байгаа юм (毕得, 1992:27). Чоныг бишрэн шүтдэг тул, өөрийгөө ч чоно шиг эрэлхэг баатарлаг юунаас ч айхгүй зоригтой болоосой хэмээн бэлгэдэж чоноор овог аймгийн нэр цаашлан хүний нэр болгож авдаг заншил тэнд оршиж байжээ. “Сүй улсын бичиг, түрэгийн цадиг”-т: Хүннүгийн нэг овог нь чоныг онгон шүтээн болгодог болхоор өөрийгөө чонос овог (狼氏) гэж нэрийдэж, чонын толгойгоор овгийнхоо туг сүлд болгож байсан гэж тэмдэглэж буй ((唐)魏徵, 1973:1863). Рашид-Ад Диний “Судрын чуулган”-д царай лянхуан ах Байшинхор догшин үхсэнд бэлэвсэн бэргэнтэйгээ гэрлэн гэнт чоно өлөгчин чоно гэдэг хоёр хүүтэй болов. Энэ хоёр хүүхдийн үр ач нар нь үржсээр байж сүүлээр нь “Чонос” аймаг болов гэж өгүүлж буй ([波斯], 28).

“Нууц товчоо”-д тэмдэглэснийг үндэслэвэл Жамуха “Арван гурван хүрээний тулалдаан”-д Чингис хааныг ялаад Чоносын хөвгүүдийг далан тогоонд хийж буцалгасан бөгөөд бас Нэгүдэй цагаан оугийн тэргүүнийг огтолж, мориныхоо сүүлд уяж довтолгон явсан гэж буй (Баяр, 1980:115). “Судрын чуулган”-д бас Чингис хааны арван гуравдугаар хүрээ нь хэнт чоно хийгээд өлөгчин чонын хойчсоор бүрэлдсэн нэгүс аймаг ажээ ([波斯], 115).

Түүхэн тэмдэглэлийг үндэслэвэл чоно нэрт овог нийтийн тоолоос өмнө 10, 11 дүгээр зууны үед нэгэнт Монголын өндөрлөгт оршиж байжээ. “Хүвэ Иү бичиг” (“国语”)-ийн нэгдүгээр боть “Жэү Иү бичиг” (дээд)-д өгүүлсэн нь Мэү ван эзэн зөвлөгч түшмэлийн ятгал сэргээлийг үл соносон Циүван Ронг (犬戎) хэмээх аймгийг дайлан ялж “дөрвөн цагаан чоно, дөрвөн гуа марал (四百狼·四百鹿)-ыг олзлоод буцав” гэжээ (薛安勤, 1991:3). Энд ярьж байгаа “дөрвөн цагаан чоно, дөрвөн гуа марал” гэгч яриангүй чоно, марал араатныг зааж байгаа биш харин чоно марлаар онгон шүтээнээ болгосон овог аймгийг төлөөлүүлж байгаа юм. Эртний үед хятад үндэстнээс умартын нүүдэлчин үндэстнүүд дотор газар түрэн орох явдлыг ямагт чонын дайралтаар бэлгэдэн зүйрлэдэг. “Вэй улсын бичиг, ноёд хийгээд овгийн тэмдэглэл”-д бас умарт оронд “чоно” (叱奴) овогтон авай. Сүүлээр Ланг (狼) овог хэмээн халбай” гэж буй. “Вэй улсын бичиг”-ийн хоёрдугаар боть “тайжийн намтар”-т Вэн Гүвэй хэмээгчийн тавдугаар он (390 оны) есдүгээр сард “чоно аймгийг нан Чиү мөрнөө дайларун ихэд ялав. Өвлийн арван сард Юүн Зүнг газар (одоогийн Өвөр Монголын Тогтох саян) нүүлгэв” гэжээ (魏书, 1974:23). Үүнээс үзэхэд чоно аймаг албадлагаар нүүлгэгдсэний дараа овгийн нэрээ хятадаар орчуулан нэрлэсэн байна. “Вэй улсын бичиг”, “Тайж нарын намтар”-т бас Хуан Шийн хоёрдугаар он (397 он)-д урвалга гаргах гэсэн чинээн (叱奴根) аймгийг дийлж дарангуйлсан гэх тэмдэглэл буй (魏书, 1974:29). “Гэхдээ эртнээсээ сүлд төрийг хэвээр нь шүтэж овгийг ахлах эрэгтэй хүнд чоно цол өгч, эмэгтэй хүнд гуа марал цол өгдөг явдлыг хэвээр байсныг илтгэж байна” (Дулам, 1998:46)

Дээр ярьсан агуулгыг хураангуйлбал: “Монголын нууц товчоо”-д гарах бөрт чоно нь умардын бусад нүүдэлчин үндэстний онгон шүтээн болох хөх чонотой гарал нэгтэй юм. Тэр нь соёлын уламжлал шинэчлэлийн явцад хүн төрөлхтний онгон шүтээний хувиар монгол домог, домог ярианд үргэлжлэн шитчилэгдэн илрэх болжээ. Бөрт чоно нь монголчуудын өвөг дээдэс болох мөртөөн түрэгийн домог, домог ярианд харьцуулбал монгол домгийн агуулын хувьд төдий бүрэн бус болсон болвч бид домгийн харьцуулал судлалын үүднээс түүний уг дүрсийг мөшгөж чадах юм. Монгол домог, домог яриа дахь чоно нь монголчуудын өвөг дээдэс болох, дээд тэнгэртэй холбоотой, хүнийг туслан дэмждэг, хүмүүсийн сэтгэлд баатар зоригийн бэлгэдэл болдог гэх агуулгын хувьд түрэгийн чоно угсаа гарлын домог яриатай адилаартай байгаа юм.

Тал нутгийн нүүдэлчин ардууд өвс бэлчээрийн шилдгийг сонгон нүүдэллэн явахдаа овог аймгуудын хоорондоо бэлчээр ус булаалдах явдал гарах нь яриангүй. Тэр үед тэднүүст чонын эрэмгий зориг болон сүр сүлд бодогдож, мөн түүнээс олон арвин байлдааны арга бодлогыг олж сурснаас чоныг хүндэтгэн биширч, түүнийг дээдлэн хүндэлж маш олон сонин сайхан чонын тухай домог, домог яриаг зохиож уламжлан, үүний улам чонын эрэлхэг баатар, буцашгүй эрэмгий зоригийг нь бишрэн суралцаж, тэр зориг санааг өөрийн амьдрал дундаа хэрэгжүүлж, онгон шүтээний зориг санаа нь даруй энэхүү угсаа үндэстний зориг сүлд болж нэгдэж чадсан байгаа юм. Үндэстнүүдийн их нийлэл нэгдлийн явцад, шинэ нэгэн нийгмийн бүлхэм буй болж бүрэлдэхэд уулын оршиж байсан олон зүйлийн соёлд сонгож шингээх асуудал тохиолдоно. Умардын нүүдэлчин үндэстнүүдийн нийлэн нэгдэх түүхэн явцаас үзвэл монголчууд соёлын шилэлтийн асуудалд уламжлан залгамжлах овроор хандсан юм. Үүний улам үндэстний нийлэл хөгжлийн явцад шүтээний байр суурь нь улам чинагшид хөгжин бэхжиж чаджээ. Хүннү, түрэг, монгол энэ гурван том нүүдэлчин үндэстэн урьд хожид монголын өндөрлөгийг эзэрхэж адил газар оронд адилхан амьдралын арга маягаар оршиж байсны улам хэдийбээр угсаа гарлын домог, домог яриан үйл явдын мотив нь адилгүй боловч домгийн цөм болох чоно шүтээний байр суурь нь хувирсангүй мөртөөн эдгээр үндэстний соёл, зориг санааны бэлгэдэл болж, бүхий л умарт оронд уламжлагдан дэлгэрчээ.

Abstract

It is a widespread phenomenon that many people relate their ancestors with wolves in Mongolian, Turkish myths and fairy tales. However, the motif of events in ancestors' myths are diverse, the core status of the Wolf Worship is invariable and become the culture, spirit symbols of these nations, even spread throughout the north area. The role of wolf appeared in Mongolian myths has a lot in common with which in Turkish myths. Their primary motifs and basic understanding are roughly similar and both of them focus on the blue sky which is the supreme faith of the Shaman.

Keyword: *Mongolian, Turkish linguistics, myth, fairy tale, role of wolf*

Ном зүй

Баяр – ᠖ᠣᠨ ᠰᠡᠭᠦ᠋ᠢᠵᠤᠨ : 《ᠰᠣᠩᠸᠠᠳᠤ ᠶᠤᠬᠤᠨ (ᠶᠤᠫᠤᠨ) ᠰᠣᠨ ᠰᠣᠨᠸᠠᠳᠤ ᠲᠤ ᠮᠠᠨᠤ ᠰᠣᠨ ᠰᠣᠨᠸᠠᠳᠤ》·1980.

[illegible]

Дамдинсүрэн Ц. – [ᠲᠠᠮᠳᠢᠨᠰᠦᠷᠡᠩ] , ир, ᠑᠙6᠒/᠐᠕ᠱᠣᠭ : «ᠲᠤᠨᠯᠤᠰ ᠲᠤᠨ ᠲᠤᠨᠲᠤᠨ ᠲᠤᠨ ᠠᠶᠢᠴ᠋ᠠ ᠸᠠᠵᠤᠨ ᠪᠠᠶᠢᠨ ᠲᠤᠨᠲᠤᠨ» , ᠲᠤᠨᠪᠠᠨ ᠲᠤᠨᠲᠤᠨ ᠲᠤᠨ ᠬᠠᠲᠤᠨ ᠲᠤᠨ
ᠠᠳᠤᠨ ᠲᠤᠨ ᠠᠲᠤᠨ , 1979.

Дулам С. – [ᠰᠣᠳᠤ] : + , ᠑᠙97 ; 《ᠰᠣᠳᠤ ᠴᠢᠨᠠᠭ ᠲᠠᠩ ᠶᠡᠭᠦᠨ》 : ᠪᠠᠵ᠋ᠠ ᠰᠣᠳᠤ ᠪᠡ ᠬᠠᠸᠠᠭ ᠲᠡ ᠨᠢᠷ᠎ᠠᠭ , 1999 .

Жангар – «**Туган**» • 1988 йил 10-сентябрда чоп этилган.

Лувсанчойдон — *ᠯᠤᠪᠰᠠᠨᠴᠣᠢᠳᠣᠨ* : 《ᠰᠣᠮᠣᠨ ᠰᠤ ᠨᠠᠭ ᠰᠠᠨᠤ ᠰᠠᠨᠤᠨᠠᠭ》 • *ᠰᠣᠮᠣᠨ ᠰᠤ ᠨᠠᠭ ᠰᠠᠨᠤ ᠰᠠᠨᠤᠨᠠᠭ* : 1981.

MHT — «ኮሎስ ኤፕሎጎግ ሳይጋላ» (ጥገላ፣ ጩራ፣ ግራጸጽ፣ ጥገላ ኮሎስ ኤፕሎጎግ ጥገላ፣ ጥገላ፣ ጥገላ፣ ጥገላ፣ 1980.

Сайнжаргал, Шаралдай – *ᠰᠠᠶᠢᠨᠵᠢᠷᠭᠠᠯ, ᠱᠤᠷᠠᠯᠳᠠᠢ* : 《ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠰᠤᠭᠢᠨᠠᠭᠤᠨ ᠰᠤᠭᠠᠨᠠᠭᠤᠨ》, ᠰᠤᠷᠠᠭᠠᠨᠠᠭᠤᠨ ᠰᠤᠭᠠᠨᠠᠭᠤᠨ ᠰᠤᠭᠠᠨᠠᠭᠤᠨ, 1983.

Хүрэлшаа – *ᠬᠡᠷᠡᠯᠰᠠᠭ᠎ᠠ*: 《ᠱᠣᠩᠭ᠎ᠠ ᠵᠣᠪᠠᠨ ᠰᠤ᠋ᠵᠤᠨ》 + *ᠰᠤᠵᠤᠨᠰᠣᠭᠤᠨ* ᠰᠤ ᠠᠳᠠᠨ ᠰᠤ᠋ᠵᠤ ᠠᠵᠠᠨᠭᠠ, 1996.

[illegible][illegible]

(唐)魏徵、令狐德棻撰：《隋书》卷八十四，《突厥传》，中华书局，1973年版。

[波斯]拉施特主编余大钧，周建奇译，《史集》，第一卷，第二分册

「波斯」拉施特主编余大钧，周建奇译，第一卷，第二分册

《魏书》卷二《太祖纪》，中华书局，1974年版。

毕树：《哈萨克民间文学概论》，中央民族大学出版社，1992年版。

满都胡主编：《中国阿尔泰语系诸民族神话故事》，民族出版社，1997年版。

耿世民译：《乌古斯可汗的传说》，新疆人民出版社，1980年版。

耿世民译：《乌古斯可汗的传说》，新疆人民出版社，1980年版。

薛安勤，王连生注译：《国语译注》，吉林文史出版社，1991年版。

见突厥文，《厥特勤碑》，岑仲勉《突厥史集》(下册)，中华书局，1958年版。

魏收：《魏书》，卷一零三，《高车传》，中华书局，1974年版。